

Хуулийн төслийн танилцуулга:

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах
мэргэжилтэн Сү.Энхцэцэг

2010-03-04

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

**Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл,
шаардлага:**

1. Хууль зүйн шаардлага:

- Улсын Их Хурлын 2008 оны 35 дугаар тогтоолын 4.5.9-д “Олон нийтийн мэдээллийн эрх чөлөөг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно”,
- Улсын Их Хурлын 2009 оны 38 дугаар тогтоолын 107-д “Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг баталгаажуулан хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр Хэвлэлийн эрх чөлөөний тухай” хуулийг боловсруулахаар тус тус заасан байна.

2. ПРАКТИК ШААРДЛАГА:

- Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй” гэж баталгаажуулсан.
- Хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг төрөөс хараат бус ангид байлгах, хэвлэл мэдээллийн байгууллагын чөлөөт үйл ажиллагааг дэмжих
- Даяаршлын нөлөө, технологийн үсрэнгүй хөгжлийн нөлөөгөөр сүлжээгээр дамжих мэдээ, мэдээллийн тоо хэмжээ, хамрах хүрээ огцом өсч хэвлэл, мэдээллийн салбарын үйл ажиллагаа боловсронгуй болж байна.
- 1998 онд хууль батлагдах үед Монгол Улсын хэмжээнд **8** телевиз, **51** студи, **561** сонин хэвлэл, **9** фм радио албан ёсоор бүртгэлтэй байсан бол өнөөдөр энэ тоо зөвхөн Улаанбаатар хотод гэхэд телевиз **24**, тогтмол нийтлэгддэг сонин хэвлэл **139**, фм радио **20** болтлоо өсч үүнтэй зэрэгцэн олон зуун дотоод, гадаадын цахим хуудсаар мэдээ, мэдээллийг түгээх болсон.

Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

- Уг хууль нь 5 бүлэг, 16 зүйлтэй.

Хуулийн төсөлд дараахь зохицуулалтыг тусгана. Үүнд:

1. Хэвлэл мэдээллийн байгууллага болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэсэн хоёр ойлголтыг тодорхойлно. Тухайлбал: **Хэвлэл мэдээллийн байгууллага** нь хэвлэл мэдээллийн хэрэгслийг эрхлэн гаргадаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бол **хэвлэл мэдээллийн хэрэгсэл** гэдэг нь хэвлэл мэдээллийн байгууллагаас мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх арга, хэрэгсэл гэж үзнэ.
2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дараахь зорилгоор **гагцхүү хуульд заасан үндэслэл байвал хязгаарлаж** болохоор тусгана. Үүнд:
 - 1/ онц болон дайны байдлын хэв журмыг хангах;
 - 2/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, нийгмийн хэв журмыг хангах;
 - 3/ бусдын эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах;
 - 4/ хуулиар төр, байгууллага, хувь хүний нууцад хамааруулсан мэдээ, мэдээллийг хамгаалах.

Үргэлжлэл:

3. УИХ-аас хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт бүхий хууль батлахдаа түүний үндэслэл, шаардлагыг хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад заавал тусгасан байх зохицуулалтыг оруулна. Мөн төрийн байгууллага, албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэвлэл мэдээллийн эрх чөлөөг **хязгаарласан тушаал, шийдвэр гаргахыг хориглох** тухай заалтыг оруулна.
4. **Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааны баталгааг** оруулж өгнө. Тухайлбал, тус байгууллага нь мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхтэй байхаар, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргах мэдээ, мэдээлэлд төрөөс хяналт тавихыг хориглосон зохицуулалтыг тусгана.

Үргэлжлэл:

5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хараат бус, мэргэшсэн үйл ажиллагааг дэмжих, олон нийтийн хяналт, төлөөллийг хэрэгжүүлэх, хэвлэл мэдээллийн салбарын өөрийгөө хянах, зохицуулах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор **Хэвлэл мэдээллийн Зөвлөлийг** хуулиар байгуулж тус зөвлөлийн бүрэн эрх, үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг оруулна.
6. Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг шууд хориглосон хуулийн зохицуулалтаас татгалзаж, өнөөгийн цаг үеийн шаардлагад нийцүүлэн **тодорхой хязгаарын хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байж болох** талаар зохицуулна. Тухайлбал,

Төрийн байгууллага нь:

- төрийн байгууллагын үйл ажиллагаа сурталчлах, зар , мэдээлэл түгээх;
- хууль болон нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг нийтэд таниулах, мэдээлэх;
- Хэвлэл мэдээллийн агентлаг (Монгол Улсын Засгийн газар нь хэвлэл мэдээллийн салбарт олон улсын байгууллага, гадаад улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн байдал, гадаад бодлого, олон улсын харилцааны талаарх мэдээ, мэдээллийг хилийн чанадад түгээх зорилгоор)

Үргэлжлэл:

7. Хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэлийн бодлогын хүрээнд цацагдсан мэдээ, мэдээллийн улмаас учирсан хохирол болон бусад хариуцлагыг тухайн хэвлэл мэдээллийн **байгууллага хүлээхээр** тусгана. Харин зар сурталчилгааны болон захиалгат нийтлэл, нэвтрүүлэгтэй холбогдон үүсэх хариуцлагыг тухайн **захиалагч этгээд хариуцна.**
8. **Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон нарийвчилсан харилцааг** Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиас гадна **тусдаа хуулиар зохицуулахаар** тусгана. Тус хуулиар хэвлэл мэдээллийн байгууллагыг байгуулах, бүртгүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллагын редакци, сэтгүүлчийн эрх, үүрэг, түүнчлэн бодит бус, худал мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан нөхцөлд залруулга хийх журам зэргийг зохицуулна.

Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төсөл

- Сэтгүүлч гэж хэн бэ? Ямар эрх, үүрэг эдэлдэг? /хариуцлага/
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж юу вэ? Түүний редакцийн эрх зүйн байдал??
- Бодит байдалд нийцээгүй мэдээ, мэдээлэлд хэрхэн залруулга хийх вэ??
- Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх ямар хариуцлага хүлээлгэх вэ??



Шаардлагаас үндэслэн

Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг нэг талаас **баталгаатай нөгөө** талаас **хариуцлагатай** эдлүүлэх, цаг үедээ нийцсэн, хариуцлагатай сэтгүүл зүйг бий болгоход чиглэсэн зохицуулалт бүхий хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

1. Төслийн **нэгдүгээр бүлэгт** хуулийн зорилт, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэр томъёоны тайлбар, хуулийн үйлчлэх хүрээ, зарчим, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг буруугаар ашиглах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хуульд зааснаас бусад хэлбэрээр хяналт тавихыг хориглохтой холбогдсон нийтлэг харилцааг тусгана.
2. **Хоёрдугаар бүлэгт** олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүсгэн байгуулагч, редакц, тэдгээрийн эрх зүйн байдал, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүртгэл, редакцийн дүрэмтэй холбогдсон үйл ажиллагааны зохион байгуулалт, мэдээллийн агентлагийн талаарх харилцааг хуульчилна.

Үргэлжлэл:

3. **Гуравдугаар бүлэгт** олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх журам, олон нийтийн хэвлэлийн нийтлэлийн дугаарт тавигдах шаардлага, хувь хэмжээ, заавал нийтлэх, нэвтрүүлэх мэдээ, зар сурталчилгаа, эротик нийтлэл, нэвтрүүлэг гаргах журмыг нарийвчлан тусгана.
4. **Дөрөвдүгээр бүлэгт** бодит байдалд нийцээгүй мэдээ, мэдээлэлд залруулга хийхтэй холбогдсон журмыг заана.

Үргэлжлэл:

5. **Тавдугаар бүлэгт** сэтгүүлчийн эрх, үүргийг нарийвчлан заана. Нууцалсан мэдээлэл, нууц бичлэгийг зөвшөөрөх нөхцөл, сэтгүүлчийн эрхийг буруугаар ашиглахыг хориглох талаар зохицуулна.

6. **Зургаадугаар бүлэгт** олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг хуульчилна.

Анхаарал тавьсанд баярлалаа!